



**БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ**

**№03/6.1-1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН  
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалтын удирдамжийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо: ...../...../.....

Хяналт шалгалт дууссан огноо: ...../...../.....

Шаардлага хангасан  
асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн  
хувь

Эрсдэл үүсэх  
магадлал

Шаардлага хангаагүй  
нийт оноо:

Эрсдэл үүсэх  
магадлалын хувь

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ**

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Баталсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангасаагүй		
	1	2	3	4	5	6
<b>I.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>			<b>0</b>	<b>140</b>		
1.	Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1, 7.6 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 19, 21 дүгээр зүйлийн холбогдох заалтууд, Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 2.1, 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.3, 2.4 дэх заалтууд	Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, нөхцөл шаардлагын заалтууд хангагдсан.	0	10		
2.	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1, 33.2.2 дахь заалтууд	Эрхлэгч нь багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн, боловсролын удирдлага, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн, боловсролын сургалтын	0	10		

		байгууллагад тасралтгүй 10-с доошгүй жил ажилласан үүнээс боловсролын сургалтын байгууллагад багшаар 6 –с доошгүй жил, арга зүйчээр 4-өөс доошгүй жил ажилласан мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байна.				
3.	Боловсролын ерөнхий хуулийн 8.1, 8.2, 8.3 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 4 болон 21 дүгээр зүйлийн холбогдох заалтууд	Хамран сургах тойргийн хүүхдийн дэлгэрэнгүй судалгаа гаргаж, үндсэн болон хувилбарт сургалтад хамруулдаг, энэ чиглэлээр хийгдэх ажлыг төлөвлөж, зохион байгуулдаг	0	5		
4.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 3.1, 4.3 дахь заалт, Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 8.1 дэх заалт	Хамран сургах тойргийн 2-5 настай хүүхдийг үүнээс 5 настай хүүхдийг заавал бүртгэж элсүүлнэ. 200-аас доошгүй цагийн сургалтад хамруулсан эсэх,	0	20		
5.	Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5.2, 7,3 дахь заалтууд, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1 дэх заалт	Багшаа хөгжүүлэх, хөтөлбөр, төлөвлөгөөтэй, ажилтны хөдөлмөрийн үр дүнг үнэлж, урамшуулан, дэмжлэг үзүүлж, хариуцлага тооцдог.	0	5		
6.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.5 дахь заалтууд	Цэцэрлэг нь хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхдэд боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.	0	10		
7.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.2 дахь дахь заалт, 25 дугаар зүйл	Цэцэрлэгийн арга зүйн удирдлагыг багш нарын зөвлөл , мэргэжлийн багш нарын бүлэг хэрэгжүүлж арга зүйч нь сургалт үйл ажиллагааг удирдан чиглүүлж, багшид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгдөг.	0	10		
8.	Боловсролын ерөнхий хуулийн 34.2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 23.2.1 дэх заалт, 24 дүгээр зүйл	Цэцэрлэгийн зөвлөл байгуулан төлөөлөл бүрдсэн, хөгжлийн бодлого, боловсруулах, санал, дүгнэлт гаргах, дүрэм баталж мөрддөг.	0	5		
9.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.5 дахь заалт	Цэцэрлэгийн эрхлэгч нь хүүхэд, багш, ажилтны сургалтын орчин дахь эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.	0	10		
10.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.1, 17.1.2, дахь заалтууд	Цэцэрлэгийг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, ажилтныг тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх,	0	10		
11.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 6.2, 6.2.1, 6.3, 6.3.1, 6.3.2, 6.3.3, 6.4, 6.6 дахь заалтууд	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж тайлагнаж ажилласан.	0	10		

12.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 7.4.2, 7.4.3 дахь заалтууд	Цэцэрлэгийн бага болон холимог бүлэгт 20, дунд, ахлах, бэлтгэл бүлэгт 25, 24 цагийн үйл ажиллагаатай бүлэгт хүүхдийн наснаас хамаарч 20-25 хүүхэдтэй байхаар бүлгийн зохион байгуулалт хийсэн. Цэцэрлэгийн бүлэг нь гэрт байрладаг бол гэрийн зай талбайгаас шалтгаалан 20-25 хүүхэдтэй эсэх,	0	10		
13.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 7.8, 7.8.1, 7.8.2, 7.9, дэх заалтууд	Цэцэрлэг нь үйл ажиллагааны цагаас хамааран цэцэрлэгт хүүхэд хүлээн авах, тарах, хооллох, нойрсох хугацааг багш, ажилтны оролцоотой тогтоон баталгаажуулж, түүнд нийцүүлэн бүлгийн өдрийн дэглэмийг ялгаатай төлөвлөж мөрдөнө.	0	5		
14.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 7.11, 7.11.1, 7.11.2, 7.11.3 дахь заалтууд	Цэцэрлэг нь хүүхдийн хамгаалуулах эрх, аюулгүй, сайн сайхан байдлыг хангахад багш, ажилтан, гэр булд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий "Хүүхэд хамгааллын баг"-ийг байгуулан ажиллуулна.	0	10		
15.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 8.4.дэх заалт	Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн бодит байдалд нийцүүлэн хөгжих, сурах эрхийг хангах орон тооны бус 7-9 хүний бүрэлдэхүүнтэй "Дэмжлэгийн баг" -тай байх ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн элсэлт, бүртгэлийг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөмж чиглэл өгнө.	0	10		
<b>II. СУРГАЛТЫН ОРЧИН</b>			<b>0</b>	<b>180</b>		
16.	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.2.3 дахь заалт	Цэцэрлэгийн зориулалтын байртай.	0	10		
17.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4 дэх заалтууд, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.2 дахь заалт	Хүүхдийн ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчныг бүрдүүлсэн.	0	5		
18.	Боловсролын ерөнхий хуулийн 39.1 дэх заалт, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.2.2, 5.2.3 дахь заалтууд	Ойр орчиндоо зүлэг, мод тарих, байгальд ээлтэй, орчин бүрдүүлсэн.	0	10		
19.	Боловсролын ерөнхий хуулийн 39.1 дэх заалт, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.2.2, 5.2.3 дахь заалтууд	Барилга байгууламж нь сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангаж, орох, гарах, хаалганы шат довжоог хальтиргаанаас хамгаалсан, мөн хаалганы гадна орчинд цардсан талбайтай.	0	5		

20.	Боловсролын ерөнхий хуулийн 39.5, 39.6 дахь заалтууд, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.1.1, 5.1.5 дахь заалтууд	Цэцэрлэг нь эзэмшил газартай. гэрчилгээ, кадастрын зургаар баталгаажсан, замын тэмдэг тэмдэглэгээтэй.	0	10		
21.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.1.1, 5.1.5 дахь заалтууд	Барилга байгууламж, эзэмшил газар нь стандартын шаардлага хангасан хашаатай, түүнийг зориулалтын дагуу ашигладаг.	0	5		
22.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.1.2, 5.2.4, 5.2.8, 5.3.4, 5.3.7, 5.3.8, 6.2.2, 8.1, 8.2, 8.5, 8.6, 8.7, 10.1 дэх заалтууд	Цэцэрлэг нь эрүүл, аюулгүй, хамгаалагдсан, ээлтэй орчин бүрдүүлсэн. Цэцэрлэгийн гадна, дотор талд шаардлага хангасан гэрэлтүүлэг, камертай. /Хугацаа хүчинтэй, хадгалах хоног 30-аас дээш/	0	10		
23.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.1.3, 5.1.4, 5.1.6 дахь заалтууд	Цэцэрлэг нь аюулгүй байдлын дохиоллын систем, галын дүгнэлт, аянга зайлуулагч, газардуулгатай.	0	10		
24.	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.3 дахь заалтууд, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 6.1.1, 6.1.2, 6.2.1, 6.4.1, 6.4.2 дахь заалтууд	Гадна тоглоом, биеийн тамир, туршилтын талбайд тавигдах шаардлага хангасан талбайтай тогтмол ашигладаг.	0	20		
25.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.3.7 дахь заалт	Сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, ном бичгийн хэрэгсэлээр хангагдсан.	0	5		
26.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.3.8 дахь заалт	Цэцэрлэгийн болон анги танхимын тавилга хэрэгслийг хөдөлгөөнгүй, тогтвортой байрлуулж, хүүхэд бэртэж, гэмтэхээс урьдчилан сэргийлсэн.	0	5		
27.	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.3 дахь заалтууд, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.5.1, 5.5.2, 5.5.3 дахь заалтууд	Хүүхдийн бие эрхтэнд гэмтэл учруулах хурц үзүүр, ирмэгтэй болон шил төмрөөр хийсэн тавилга, тоног төхөөрөмж ашигладаггүй.	0	5		
28.	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.3 дахь заалтууд, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 6.3.1 дэх заалт, MNS ISO8124 4:2010	Хөгжмийн болон биеийн тамирын заал, танхим нь хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон, техник хэрэгсэл тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг бусад хэрэгслэлээр хангагдсан.	0	10		
29.	Боловсролын ерөнхий хуулийн 16.1, 16.3 дахь заалтууд, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS ISO8124 4:2010	Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон тоглоомоор хангагдсан.	0	10		

	"Тоглоомын аюулгүй байдал" стандарт, Хүүхдийн тоглоомын талбай Ерөнхий шаардлага MNS 6751:2019					
30.	Хүүхдийн тоглоомын талбай Ерөнхий шаардлага MNS 6751:2019, 7.10 дахь заалтууд	Тоглоомын талбайг бүхэлд нь хамруулсан камержуулалттай эсэх,	0	10		
31.	Хүүхдийн тоглоомын талбай Ерөнхий шаардлага MNS 6751:2019, 8.4 дэх заалт	Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуу нь хүүхэд тээгэлдэх бүдрэхээргүй тэгш, цэвэрлэхэд хялбар, хур тунадас тогтохооргүй, хурц ирмэггүй, гогцоогүй.	0	10		
32.	Хүүхдийн тоглоомын талбай Ерөнхий шаардлага MNS 6751:2019, 9.3 дахь заалт	Хүүхдээ насны онцлогт тохирсон тоглоом дээр тоглуулах, тоглож байх үед хяналт тавьдаг.	0	10		
33.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS6558:2015 стандартын 5.1.4, 5.1.6 дахь заалтууд	Тоглоомын талбайд элсээр тоглох, элсийг бохирдлоос хамгаалах хэсэгтэй, талбайд хүүхдийн тооноос хамааран сүүдрэвчтэй байна.	0	10		
34.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 9.14 дэх заалт	"Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчныг үнэлэх шалгуур үзүүлэлт"-ийн дагуу өөрийн үнэлгээг жил бүр, аюулгүй байдалд тодорхой давтамжтай хяналтыг хийж, шаардлагатай хариу арга хэмжээ авна.	0	10		
35.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 9.13 дахь заалт	Цэцэрлэг нь холбогдох мэргэжлийн байгууллагаас баталсан гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байна.	0	10		
<b>III. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР</b>			<b>0</b>	<b>30</b>		
36.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.2 дахь заалт	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр-ийг жил (сургалт, үйл ажиллагааны хичээлийн жилийн төлөвлөгөө), 7 хоног (1-3)хоног, өдөр тутмын төлөвлөлтөөр хэрэгжүүлэх.	0	10		
37.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.2 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйл	Хүүхдэд өдөр тутмын үйл ажиллагааны явцад онцлог өөрчлөлт, хандлагын талаар ажиглалт хийж баримтжуулан, "Хувийн хавтас" нээж, тэмдэглэл хөтөлж, эцэг эх, асран хамгаалагчдад нь танилцуулдаг.	0	10		
38.		Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур хангасан байдлыг насны ангиллаар гаргаж, хүүхдийг өөртэй нь харьцуулж үнэлгээ хийж ажилладаг.	0	10		
<b>IV. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН</b>			<b>0</b>	<b>40</b>		
39.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай	Цэцэрлэг нь мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан.	0	10		

	хуулийн 16.1, 16.2 дахь заалтууд					
40.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 4.4.2 дахь заалт	Цэцэрлэгийн үндсэн бүлэгт ажиллах багшийн туслах нь багшийн туслах бэлтгэх зөвшөөрөлтэй сургалтын байгууллагын сургалтад хамрагдаж, бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх чиглэлээр бэлтгэгдсэн байна.	0	10		
41.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14.1 дэх заалт	Цэцэрлэг нь эрхлэгч, арга зүйч, багш, багшийн туслах, эмч, тогооч болон үйлчилгээний ажилтантай.	0	5		
42.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14.2 дахь заалт	Цэцэрлэгийн нэг бүлэгт багш, багшийн туслах ажилладаг.	0	5		
43.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15.1.2 дахь заалт	Сургалтын үйл ажиллагааны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын шаардлагыг хангасан.	0	5		
44.	Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 10.1, 11.2 дахь заалтууд, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн холбогдох заалтууд	Багш мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, заах арга, ур чадвараа дээшлүүлсэн.	0	5		
<b>V.ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ОРОЛЦОО</b>			<b>0</b>	<b>20</b>		
45.	Боловсролын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн холбогдох заалтууд,	Цэцэрлэгийн бодлого, төлөвлөлт, шийдвэрт эцэг, эх, асран хамгаалагчид санал өгөх, мэдээлэл, зөвлөгөө чөлөөтэй авах, хяналт тавих нөхцөл бүрдсэн.	0	5		
46.	Боловсролын ерөнхий хуулийн 40.3 дахь заалт, БЕГ-ын даргын тушаалаар батлагдсан А/276 дугаар тушаал	Цэцэрлэг нь хүүхдийн эрүүл, аюулгүй сурч хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх талаар харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, эцэг, эх, асран хамгаалагчтай гэрээ байгуулсан.	0	5		
47.	Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 5.1.1-5.3.2 дахь заалтууд	Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дүрмийн дагуу зохион байгуулдаг.	0	10		
<b>VI. ДОТООД ХЯНАЛТ</b>			<b>0</b>	<b>20</b>		
48.	Монгол Улсын Засгийн газрын 311 дүгээр тогтоол	Дотоод хяналтын ажилтантай, эсвэл ажилтныг томилон албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийг зааж оруулан, ажиллах журам, төлөвлөгөө гаргаж, ажилладаг.	0	5		
49.		Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаандаа эрсдэлийн үнэлгээ, шинжилгээ хийж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.	0	5		
50.	Монгол Улсын Засгийн газрын 311 дүгээр тогтоол	Дотоод хяналтын тогтолцоог төлөвшүүлэн дутагдлыг арилгах арга зүйн зөвлөмж	0	10		

		гаргаж, арга хэмжээ авч үр дүнг хамт олонд тайлагнадаг				
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>430</b>		

**III. ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ**

**ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

.....  
 ...  
 .....

**БИЕЛЭЛТ**

.....  
 .....

<b>БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж,</i>
<i>/овог, нэр/</i>	<i>/овог, нэр/</i>	<i>/овог, нэр/</i>
<i>/гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/гарын үсэг, тамга/</i>

Тайлбар:

.....  
 .....

**IV. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ**

**ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

.....  
 .....

**БИЕЛЭЛТ**

.....  
 .....

<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
Хяналт шалгалт хийсэн огноо: 20__он__сар__өдөр		
<i>Албан тушаалын нэр</i>	<i>Албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж,</i>
<i>/овог, нэр/</i>	<i>/овог, нэр/</i>	<i>/овог, нэр/</i>
<i>/гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/гарын үсэг, тамга/</i>

Тайлбар:

Их эрсдэлтэй >=50%

Дунд эрсдэлтэй [30%-49%]

Бага эрсдэлтэй <=29%